

“МОГОЙН ГОЛ” ХК-ИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Могойн гол ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны тайлан

Эрхэм хүндэт ТУЗ-ийн дарга, гишүүд Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Манай компанийн хамт олон бид Монгол Улсын компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн хурлын шийдвэрийг хэрэгжүүлэн, 2022 оны бизнес төлөвлөгөөг хугацаанд нь ханган биелүүлэхийн төлөө бүхий л нөөц бололцоогоо дайчлан ажиллаж ирснээ та бүхэнд хүргүүлж байна.

Удирдлага, зохион байгуулалтын талаар

Тайлангийн хугацаанд хувь нийлүүлэгчдийн хурлыг-2, ТУЗ-ийн хурлыг 6 удаа хуралдуулж, 2022 оны үйлдвэрлэлийн бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалт, үйлдвэрийн түүхий эд материалыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцүүлэн батлуулж цаашдын ажилд чиглэл удирдлага болгон ажиллахаас гадна цаг үеийн асуудлаар холбогдох шийдвэрүүдийг гарган ажиллалаа.

2022 онд захирлын 131 тушаал гаргаснаас боловсон хүчний холбогдолтой 91, үйл ажиллагааны холбогдолтой 40 тушаал тус тус гаргалаа. Дээд болон орон нутгийн байгууллагуудад 180 ширхэг албан бичиг явуулж шаардлагатай хариуг авснаас гадна төрийн болон орон нутгийн байгууллагаас ирсэн албан бичгийг холбогдох албан тушаалтанд өгч асуудлыг шийдвэрлэж хариуг хүргүүлэв.


Тайлант онд нийт 60 ажлын байранд 110 ажилтан ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 60 ажлын байранд 114 ажилтан тогтмол ажилласан байна. Шинээр байнгын болон түр ажлын байранд нийт 44 иргэнийг авч ажиллуулсан. Зарим ажлын байранд ажилчдыг эрх олгох болон мэргэшүүлэх сургалтанд бүрэн хамруулав.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны талаар:


2022 оны 3 р сараас засвар үйлчилгээний ажлыг эхлүүлж, 4-р сараас хайгуулын V-VII-р огтлолын хооронд 1890-р түвшинд “HYUNDAI 520” экскаватороор хөрс хуулалтын ажлыг эхлүүлж, хоногт 2 ээлжээр 12 цагийн тулаагаар долоо хоногийн ажлын 5 өдөрт ажиллаж байгаад, ЭКГ 5А экскаваторыг шаардлагатай засвар үйлчилгээг хийж дуусган 7 дугаар сараас эхлэн V, VI, VII огтлолд тус хоёр экскаваторыг зэрэг ажиллах нөхцөлийг бүрдүүлэн 6-7 автосамосвалыг ээлж тус бүр дээр хуваарилж, мөн энэ сараас ээлжийн системд өөрчлөлт оруулан 14/7 ростероор гурван ээлжээр ажиллаж хөрс хуулалтын ажлыг эрчимжүүлэн ажиллалаа.



2022 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ (M³)



2022 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ТЕХНИКЭЭР (M³)



2022 онд 764,1 мянган м³ хөрс хуулалтын ажлыг хийж гүйцэтгэн суналын дагуух урт нь 255 метр, дундаж зузаан нь 7,5 метр, нийт 12300 м² талбай бүхий 120 мянган тонн коксжих нүүрс, суналын дагуух урт нь 90 метр, дундаж зузаан нь 5 метр, нийт 4620 м² талбай бүхий 30 мянган тонн эрчим хүчний нүүрсийг тус бүр олборлож, 130,3 мянган тонн нүүрсийг борлуулсан.

Хөрс хуулалтын ажлыг хийх үндсэн тоног төхөөрөмжүүд

- ЭКГ-5А экскаватор
- HYUNDAI 520 экскаватор
- CAT-320 экскаватор
- Хово автосамосвал 3 ширхэг
- Белаз автосамосвал 1 ширхэг
- МТ86 автосамосвал 3 ширхэг
- Өрмийн машин ECD-45E
- Бульдозер SD-23
- Дугуйт ачигч Н855
- Автогрейдер XCMG 3220

Хөрс хуулалт нүүрс олборлолтын тоон үзүүлэлтийн талаар

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь, % |
|---|------------------------------------|--------------|-----------|----------------------|
| 1 | Хөрс хуулалтын ажил, мян.метр куб | 1200.0 | 764.1 | 63.7 % |
| 2 | Олборлосон нүүрсний хэмжээ, мян.тн | Эрчим хүчний | 30.0 | 130.4 % |
| | | Коксжих | 120.0 | |
| 3 | Борлуулсан нүүрсний хэмжээ, мян.тн | 135.0 | 130.3 | 96.5 % |


Тайлант онд хийж хэрэгжүүлсэн гол ажлуудаас танилцуулбал

- Төлөвлөгөөт оны ажил эхлэхтэй холбогдуулан холбогдох яам, агентлагын газруудаар төлөвлөгөө тайланг 3-4-р сард багтаан баталгаажуулж ажиллалаа.
- 4-р сард багтаан төлөвлөгөөт уулын ажил явуулах тоног төхөөрөмжүүдэд шаардлагатай сэлбэг материалын нөөцийг бэлтгэж, их засвар үйлчилгээний ажлыг хийж ажилласан.
- 2022 оны худалдан авалтуудыг хууль журмын дагуу хийж гүйцэтгэв.
- Өдөр тутмын ажлыг тогтмол хугацаанд наряд даалгавраар ханган ажиллаж аль болох ажилчдыг ажлын цагт бүрэн ачаалалтай ажиллуулах тал дээр компанийн захирлаас үүрэг даалгавар авч ажиллаж байна.




Төлөвлөгөөт зорилтыг ханган биелүүлэхэд шаардлагатай үйлдвэрийн гол түүхий эд болох түлш, шатахуун тосолгооны материал, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах төлөвлөгөөг ТУЗ-өөр батлуулан төлөвлөгөөний дагуу хууль журмын хүрээнд нээлттэй тендер зарлан шалгаруулж, 542.7 мянган литр дизель түлшийг 1,519.6 сая төгрөгөөр, 6.7 мянган литр бензинийг 18.1 сая төгрөгөөр, тос тосолгооны материал 79.5 сая төгрөгөөр, 370.0 тн тэсрэх материалыг 1,481.7 сая төгрөгөөр, тэсэлгээний хэрэгсэл 123.9 сая төгрөгөөр, 607.0 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 240.0 сая төгрөгийн хангамжийн материал худалдан авахаар төлөвлөсөн. Гүйцэтгэлээр дизель түлш 334.6 мянган литрийг 1,118.9 сая төгрөгөөр, бензин 13.6 мянган литрийг 31.6 сая төгрөгөөр, тос тосолгооны материал 80.9 сая төгрөгөөр тэсрэх материал 224.0 тн 878.8 сая төгрөгөөр, тэсэлгээний хэрэгслийг 103.5 төгрөгөөр сэлбэг хэрэгсэл 579.7 сая төгрөгөөр хангамжийн материал 237.1 сая төгрөгөөр худалдан авалт хийж ажилласан байна.

2022 ОНД БОРЛУУЛСАН 130.3 МЯНГАН ТН НҮҮРСНИЙ БИЕТ ХЭМЖЭЭГ САРААР ХАРУУЛАХАД



Тайлант онд Хөвсгөл, Завхан аймгийн 100 гаруй байгууллага, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж 130.3 мянган тн нүүрсийг борлуулсан. Үүнээс эрчим хүчний нүүрс 30.4 мянган тн, коксжих нүүрс 99.9 мянган тн нүүрс тус тус борлуулсанаас Хөвсгөл аймагт 44.4 мянган тонн /Дулааны станц 21.9 мянган тн/, Завхан аймагт 32.8 мянган тн, Эрдэнэт хотод 53.1 мянган тн нүүрсийг тус тус нийлүүлсэн байна.


ХЭРЭГЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ХУДАЛДАН АВСАН НҮҮРСИЙГ ӨМНӨХ ОНТОЙ ХАРЬЦУУЛБАЛ:



Үйлдвэрийн төлөвлөгөөт зорилтын биелэлтийн талаар:

2022 онд 1.2 сая.м³ хөрс хуулалтын ажил хийж, 115.0 мянган тн нүүрс олборлон 135.0 мянган тонн нүүрс борлуулах зорилт тавин ажиллаж, 764.1 мянган м³ хөрс хуулалтын ажил хийж, 130.3 мянган тн нүүрс борлуулсан байна. Тайлант хугацаанд нүүрсний борлуулалтын төлөвлөгөө 96.5 хувиар биелж, урьд онтой харьцуулахад 30.3 мянган тн буюу 30.3 хувиар давуулан биелүүлсэн байна. 2022 онд 6,811,255.0 мянган төгрөгийн борлуулалт хийж, 6,638,013.2 мянган төгрөгийн зардал гарган, 155,917.6 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөснөөс, 7,045,104.9 мянга төгрөгийн борлуулалт хийж, 5,685,370.0 мянган төгрөгийн зардал гарган 1,217,179.5 мянган төгрөгийн ашигтай ажиллав.


ТӨЛӨВЛӨГӨӨТ ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТИЙГ ӨМНӨХ ОНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮДТЭЙ ХАРЬЦУУЛБАЛ





Хөрөнгө санхүүгийн талаар:

Тайлант онд компанийн нийт хөрөнгө 6,994,355.6 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 280,258.2 мянган төгрөгөөр өссөн байна. Нийт хөрөнгийг дотор нь задалбал: дансан дахь мөнгө 455,965.9 мянган төгрөг, өмнөх оноос 577195.4 мянган төгрөгөөр буурсан, нийт авлага 105,177.3 мянган төгрөг, өмнөх оноос 29.1 хувиар буурсан, бараа түүхий эд материал урьдчилж гарсан зардал 4,804,030.0 мянган төгрөг, өмнөх оноос 22.9 хувиар өссөн, бусад эргэлтийн хөрөнгө 26,511.3 мянган төгрөг, өмнөх оноос 2 хувиар буурсан байна.




Өр төлбөр эзэмшигчийн өмчийн талаар

Өр төлбөр эзэмшигчийн өмчийн дүн 6,994,355.6 мянган төгрөг байгаагийн 940,661.6 мянган төгрөг нь богино хугацаат өр төлбөр бөгөөд урд оноос 30.6 хувиар буурсан. Богино хугацаат өр төлбөрт дансны өглөг 72,639.0 мянган төгрөг, урдчилж орсон орлого 794,453.4 мянган төгрөг, татварын өглөг 45,499.1 мянган төгрөг, бусад богино хугацаат өр төлбөр 28,070.0 мянган төгрөг байна. Урт хугацаат өр төлбөр 793231.0 мянган төгрөг, эздийн өмчийн дүн 5,260,463.0 мянган төгрөг, тайлант оны цэвэр ашиг 1,217,179.5 мянган төгрөг.

Нийгмийн хариуцлагын талаар:

Тус компани тайлант хугацаанд улс, орон нутгийн төсөвт 2,165,912.2 мянган төгрөгийн татвар шимтгэл төлсөн байна. Нийт татвар шимтгэлийг задалж харьцуулбал: НӨАТ-т 704,510.5 мянган төгрөг, ашигт малтмалын нөөцийн төлбөрт 173,490.1 мянган төгрөг, Үл хөдлөх хөрөнгийн татварт 8,446.7 мянган төгрөг, ХАОАТ-т 142,698.0 мянган төгрөг, бусад 8,230.7 татварт мянган төгрөг, Агаарын бохирдлын татвар 110,000.0 мянган төгрөг, ААНОАТ-т 142,555.4 мянган төгрөг, ЭМНД-ын шимтгэлд 378,207.6 мянган төгрөг, ногдол ашигт 497,773.2 мянган төгрөгийг тус тус төлсөн байна. Тайлант онд төлсөн татвар хураамжийг өмнөх онтой харьцуулахад 83.4 хувиар өссөн байна.

2022 ОНЫ ТАТВАР, ХУРААМЖ, НОГДОЛ АШГИЙН ЗАДАРГАА




Цэцэрлэг сумын иргэдийн нүүрсний хөнгөлөлтөнд 250 тн нүүрсийг 20 хувийн хөнгөлөлтэй үнээр өгч 3,258.1 мянган төгрөг, мөн сумтай хамтран ажиллах гэрээний дагуу 58,934.8 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлэв.

Үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хийсэн хамтын гэрээг үндэслэн ажилчдын нийгмийн асуудлаар дараахь ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд: Компанийн өндөр настануудад дэмжлэг 5,171.7 мянган төгрөг, Ажилчдын өвлийн түлшний хэрэгцээнд нүүрсийг 50 хувь хөнгөлж 13,780.5 мянган төгрөг, Уй гашуу тохиолдсон 4 ажилтанд 800.0 мянган төгрөг, 8 ажилтанд буцалтгүй тусламж 12,319.2 мянган төгрөг, орон сууц барихад дэмжлэг 6,000.0 мянган төгрөг тус тус олгосон. Уурхайчдын баяр, шинэ жил, хүүхдийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэхэд 21,324.4 төгрөг, байгууллагын тэргүүний ажилчдыг шагнаж урамшуулахад 3,150.0 мянган төгрөг, өндөр насны тэтгэвэрт гарсан ажилтанд 28,070.0 мянган төгрөг, бусад хандив 24,380.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.



"МОГОЙН ГОЛ" ХК-ИЙН СҮҮЛИЙН 3 ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



Сүүлийн жилүүдэд уурхайн олборлолт, борлуулалт тогтмол өсч компаний цэвэр ашиг нэмэгдэж 2022 оны ногдол ашиг нэгж хувьцаанд 1'182 төгрөгт хүрч нийт 980'610,8 мянган төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд хуваариллаа.